2019 оны 04 сарын 30-ны өдөр Дугаар А/395 Улаанбаатар хот

Теле хяналтын камеруудыг шинээр
суурилуулах, түүнд хяналт тавих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Дэд хөтөлбөр батлах тухай” 62 дугаар тогтоол, 2019 оны “Цахим бодлогын зөвлөл байгуулах тухай” 26 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.4-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмшлийн гудамж, талбай болон авто зам, нийтлэг үйлчилгээний хяналтын чиглэлээр шинээр суурилуулах теле хяналтын камеруудын зориулалт, хэрэгцээ шаардлагыг нарийвчлан тодорхойлж, системтэй төлөвлөн зохион байгуулах, теле хяналтын камерын нэгдсэн сүлжээнд холбох, хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Г.Өлзийбаяр/-т үүрэг болгосугай.

2. Жил бүрийн Улс болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн теле хяналтын камерын дэлгэрэнгүй мэдээллийг Орон зайн мэдээллийн системд суурилсан хот байгуулалтын дундын мэдээллийн санд тухай бүр оруулах, бүртгэлжүүлж ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад, мөн хөрөнгөөр суурилуулсан хяналтын камерын засвар, үйлчилгээ, арчлалтыг хариуцан ажиллахыг өмчлөгч байгууллагуудад тус тус үүрэг болгосугай.

3. Шинээр камер суурилуулах болон засвар хийх эрэлт хэрэгцээг Орон зайн мэдээллийн системд суурилсан хот байгуулалтын дундын мэдээллийн санд үндэслэн тодорхойлж, Улаанбаатар хотын нэгдсэн теле хяналтын системийн бүртгэл хяналтыг хариуцан ажиллахыг Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар /О.Чинзориг/-т даалгасугай.

4. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх теле хяналтын камерын системийн төсөл, хөтөлбөрийн техникийн тодорхойлолт, технологийн шийдэл боловсруулахад Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар, Хот байгуулалт, хөгжлийн газар, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвөөс тус тус санал авах, суурилуулсан камер, системийг хүлээн авахад дээрх байгууллагуудын мэргэжилтнүүдийг оролцуулж ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

5.Цаашид нийслэлийн хэмжээнд суурилуулах теле камерын ажлын гүйцэтгэлийг оновчтой үр ашигтай зохион байгуулах, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч М.Халиунбатад даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ С.АМАРСАЙХАН